



**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 4/12

Улаанбаатар хот

┌ Байгууллагын жилийн эцсийн тооллогын
ажлыг зохион байгуулах тухай ┐

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэг, 72 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор батлагдсан Бэлчээрийн менежмент төслийн нэгж, орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 2.3, 5.7 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын эд хөрөнгийн 2022 оны жилийн эцсийн өмч хөрөнгийн үзлэг тооллогыг удирдан зохион байгуулж явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

	Г.Пүрэвсүрэн	Төслийн менежер
Гишүүд:	Б.Отгонжаргал	Хүний нөөцийн менежер
	Б.Зинамядраа	Механик
Нарийн бичиг:	Б.Баярцэцэг	Агрономч

2. Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс 12 дугаар сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд багтааж чанартай зохион байгуулж дуусгахыг тооллогын комисст үүрэг болгосугай.

3. Тооллогыг удирдан зохион байгуулж, хяналт тавих, үр дүнг хэлэлцэн, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, санхүүгийн тайланд бүртгэлтэй дүн мэдээг 2022 оны 12 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг тооллогын комисст даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР